

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчин бодлого зохицуулалтын газар

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн төсвийн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2021.02.25 № 07/566
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь 5 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,441,014.64	55,023,522.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	589,936.00	700,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	589,936.00	700,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	56,851,078.64	54,323,522.00
354	Хангамжийн материал	56,851,078.64	54,323,522.00
35410	Бичиг хэргийн материал	22,640,716.00	15,116,272.00
35420	Аж ахуйн материал	3,757,461.00	10,285,040.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	240,000.00
35440	Түлш, шатах тослох материал	334,011.64	-
35470	Бусад хангамжийн материал	30,118,890.00	28,682,210.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,828,897.90	50,596,904.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,828,897.90	50,596,904.06
392	Биет хөрөнгө	19,713,067.94	50,596,904.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,215,000.00	57,257,530.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,215,000.00	-35,521,042.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,931,200.00	66,245,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-144,445,178.90	-50,230,037.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,156,239.12	47,811,306.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,929,192.28	-34,966,752.50
393	Биет бус хөрөнгө	2,115,829.96	-
39301	Програм хангамж	65,188,490.00	65,188,490.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-65,072,660.00	-65,188,490.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,092,500.00	16,092,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-14,092,500.04	-16,092,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	79,269,912.54	105,620,426.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,254,743.70	30,488,071.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,254,743.70	30,488,071.29
413	Өглөг	14,254,743.70	30,488,071.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	13,664,807.70	29,788,071.29
4136	Бусад өглөг	589,936.00	700,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	300,000.00	700,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	289,936.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	65,015,168.84	75,132,354.77
51	Засгийн газрын хувь оролцоо	65,015,168.84	75,132,354.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,450,991.00	186,808,521.00
51101	Өмч: - төрийн	164,450,991.00	186,808,521.00
512	Хуримтлагдсан үр дүн	-102,776,696.63	-111,676,166.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-102,776,696.63	-99,435,822.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	-12,240,344.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,340,874.47	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	79,269,912.54	105,620,426.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	898,936,236.00	1,053,416,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	589,936.00	3,681,800.00
122	Тусламжийн орлого	-	3,681,800.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,681,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	898,346,300.00	1,049,734,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	898,346,300.00	1,009,734,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	898,346,300.00	1,009,734,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	916,434,438.56	1,073,862,794.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,434,438.56	1,073,862,794.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,552,532.56	1,052,605,326.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,567,919.16	607,458,781.34
210101	Үндсэн цалин	475,427,315.16	528,054,694.34
210102	Нэмэгдэл	46,680,604.00	52,944,087.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,460,000.00	26,460,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,739,660.38	81,877,595.29
210201	Тэтгэврийн даатгал	53,165,291.18	57,923,535.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,643,742.30	5,820,733.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,489,348.46	4,681,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,605,684.60	1,707,138.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,835,593.84	11,744,788.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,590,400.00	10,143,080.00
210301	Гэрэл, цахилгаан	215,400.00	-
210304	Байрны түрээс	1,375,000.00	10,143,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	93,556,843.32	173,936,540.50
210401	Бичиг хэрэг	21,155,899.00	65,348,808.00
210402	Тээвэр, шатахуун	17,393,691.32	14,375,941.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,669,606.00	19,228,670.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,337,647.00	74,983,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,403,100.00	716,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,236,200.00	716,000.00
210604	Урсгал засвар	3,166,900.00	-
2107	Томилолт, зочны зардал	6,132,700.00	624,340.00
210702	Дотоод албан томилолт	5,884,400.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	248,300.00	624,340.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,748,880.00	148,426,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,594,120.00	127,820,185.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	19,739,760.00	17,031,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,300.00	209,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	605,000.00	3,070,756.00
210807	Газрын төлбөр	433,700.00	294,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,813,029.70	29,422,093.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,364,562.00	14,002,950.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,448,467.70	15,419,143.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,881,906.00	21,257,468.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,375,543.00	19,668,516.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,810,691.00	19,668,516.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,564,852.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,506,363.00	1,588,952.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,506,363.00	1,588,952.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,498,202.56)	(20,446,494.14)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	8,206,150.07
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	8,206,150.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	8,206,150.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,498,202.56)	(12,240,344.07)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	898,936,236.00	1,050,434,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	898,936,236.00	1,050,434,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	898,346,300.00	1,009,734,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	898,346,300.00	1,009,734,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	589,936.00	700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	898,936,236.00	1,050,434,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,936,236.00	1,050,434,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	825,645,546.00	1,022,445,347.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,663,200.00	585,173,500.00
210101	Үндсэн цалин	390,677,313.00	402,872,675.95
210102	Нэмэгдэл	97,065,887.00	129,380,824.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	52,920,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,020,300.00	78,998,500.00
210201	Тэтгэврийн даатгал	44,213,900.00	55,591,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,201,600.00	5,851,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,161,200.00	4,681,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,040,300.00	1,170,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,403,300.00	11,703,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,435,820.00	12,784,000.00
210301	Гэрэл, цахилгаан	215,400.00	-
210304	Байрны түрээс	10,220,420.00	12,784,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,208,300.00	51,082,526.90
210401	Бичиг хэрэг	16,917,600.00	15,706,626.90
210402	Тээвэр, шатахуун	13,110,800.00	11,078,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,478,200.00	17,614,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,701,700.00	6,682,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,140,400.00	5,918,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,732,000.00	5,167,000.00
210604	Урсгал засвар	10,408,400.00	751,500.00
2107	Томилолт, зочны зардал	15,680,100.00	2,044,300.00
210702	Дотоод албан томилолт	7,680,100.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,000,000.00	2,044,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,777,664.00	274,194,821.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,715,604.00	243,898,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	18,199,760.00	17,031,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,300.00	209,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	97,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,118,300.00	12,663,167.00
210807	Газрын төлбөр	433,700.00	294,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,719,762.00	12,249,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,719,762.00	4,049,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	8,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,290,690.00	27,989,152.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,194,391.00	25,700,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	37,966,323.00	23,481,254.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,564,852.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,663,216.00	2,218,946.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,096,299.00	2,288,952.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,096,299.00	2,288,952.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	250,489,989.07	418,281,854.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	250,489,989.07	418,281,854.54
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	115,653,148.25	115,653,148.25
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	-102,776,696.63	65,015,168.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,340,874.47	3,340,874.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	-99,435,822.16	68,356,043.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	3,340,874.47	-	-3,340,874.47
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	22,357,530.00	-	-	22,357,530.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-12,240,344.07	-12,240,344.07
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	-	-111,676,166.23	75,132,354.77

/төгрөгөөр/

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,010,029,500.00	1,008,145,547.90	1,883,952.10	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,029,500.00	1,008,145,547.90	1,883,952.10	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	982,922,300.00	982,445,347.90	476,952.10	100.0
210101	Үндсэн цалин	585,173,500.00	585,173,500.00	-	100.0
210102	Нэмэгдэл	422,770,000.00	402,872,675.95	19,897,324.05	95.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,483,500.00	129,380,824.05	-	118.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,920,000.00	52,920,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	78,998,500.00	78,998,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	55,591,500.00	55,591,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,851,700.00	5,851,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,681,400.00	4,681,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,170,400.00	1,170,400.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,703,500.00	11,703,500.00	-	100.0
210304	Байрны түрээс	12,784,000.00	12,784,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,784,000.00	12,784,000.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	51,530,900.00	51,082,526.90	448,373.10	99.1
210402	Тээвэр, шатахуун	16,155,000.00	15,706,626.90	448,373.10	97.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,078,500.00	11,078,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,614,800.00	17,614,800.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,682,600.00	6,682,600.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,918,500.00	5,918,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,167,000.00	5,167,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	751,500.00	751,500.00	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,044,300.00	2,044,300.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,044,300.00	2,044,300.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	234,223,400.00	234,194,821.00	28,579.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	203,898,700.00	203,898,700.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,031,600.00	17,031,600.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	209,400.00	209,400.00	-	100.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	97,000.00	3,000.00	97.0
210807	Газрын төлбөр	12,688,700.00	12,663,167.00	25,533.00	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,000.00	294,954.00	46.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,249,200.00	12,249,200.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,049,200.00	4,049,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,200,000.00	8,200,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,107,200.00	25,700,200.00	1,407,000.00	94.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,107,200.00	25,700,200.00	1,407,000.00	94.8
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,887,500.00	23,481,254.00	1,406,246.00	94.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,219,700.00	2,218,946.00	754.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,010,029,500.00	1,009,734,500.00	295,000.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,010,029,500.00	1,009,734,500.00	295,000.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,010,029,500.00	1,009,734,500.00	295,000.00	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан	36	36	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32	32	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн төсвийн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	40,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	40,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	40,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	40,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	40,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,000,000.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,000,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	40,000,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Бат-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын гэрээгээр Хаан консалтинг Аудит ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Ганцэцэг, гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Ш.Мөнхцэцэг хариуцаж гүйцэтгэв.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/115 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, УИХ-ын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх;
- Зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх талаар бодлого боловсруулахад шаардагдах зах зээлийн судалгааг үнэн зөв гаргах;
- Гадаад хамтын ажиллагааны хөгжлийн хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,069,822.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21,396.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,350.5 мянган төгрөгөөр буюу 34.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	589.9	700.0	110.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	56,851.1	54,323.5	-2,527.6
Үндсэн хөрөнгө	21,828.9	50,955.5	29,126.6
Нийт хөрөнгө	79,269.9	105,620.4	26,350.5
Өр төлбөр	14,254.7	30,488.1	16,233.4
Засгийн газрын оруулсан капитал / ЗГСан/ орон нутгийн	164,450.9	186,808.5	22,357.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	79,269.9	105,620.4	26,350.5

Авлага дансны үлдэгдэл 700.0 мянган төгрөг болж, 110.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны Төрийн сангаас авах 589.9 мянган төгрөгийн авлага төлөгдөж, тайлант онд 700.0 мянган төгрөгийн гүйлгээ нэр данс зөрүүтэй шалтгаанаар Төрийн сангийн түр дансанд байгаагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 54,323.5 мянган төгрөг болж 2,527.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50,955.5 мянган төгрөг болж, 29,126.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд урсгал төсвийн худалдан авалтаар 9,078.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 22,357.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд 158,174.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны А-1/799 дугаар шийдвэрийн дагуу 106,859.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 2019 оны 268 дугаар тогтоолын хүрээнд ШӨХТГ-ын даргын 2020 оны А/59 дугаар тушаалыг үндэслэж 51,315.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан борлуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 30,488.07 мянган төгрөг болж, 16,233.3 мянган төгрөгөөр өссөн нь НДШ, ХХОАТ-ын өглөг 29,788.1 мянган төгрөг, Хэвлэлийн хүрээлэн ХХК-д сургалтын төлбөр 700.0 мянган төгрөгийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 186,808.5 мянган төгрөг болж, 22,357.5 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2020 оны 541 дүгээр тогтоолын дагуу автомашин үнэ төлбөргүй шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 154,480.1 мянган төгрөг буюу 18.0 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 157,428.4 мянган төгрөг буюу 18.0 хувиар өссөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 3,340.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хассантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,010,029.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,010,029.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,009,734.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,008,145.5 мянган төгрөгийг зарцуулж 1,589.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрөөс 40,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс шторкны төлбөрт 12,600.0 мянган төгрөг, хэрэглэгчийн эрх танилцуулгын үнэд 5,400.0 мянган төгрөг, постер хэвлэлийн төлбөрт 17,360.0 мянган төгрөг, гарын авлага, сургалтын материал хэвлэлийн төлбөрт 4,640.0 мянган төгрөгийн нийт 40,000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 1,092,769.2 мянган төгрөгийн 32 мэдээллээс 410,478.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг шилэн дансанд байршуулж, 682,293.3 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 54,960.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг биелүүлж, 3 зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	54,960.2	2	41,295.5	1	13,664.7	75.0
Нийт дүн	3	54,960.2	2	41,295.5	1	13,664.7	75.0

Хэрэгжүүлээгүй 13,664.7 мянган төгрөгийн 1 зөвлөмжид албан шаардлага тогтоов.

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 956,855.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16,136.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 729.3 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 929,412.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 10,577.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

ЗАЛРУУЛСАН АЛДАА

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 9,100.0 мянган төгрөгийн видео контентын төлбөрийг бичиг хэргийн материал дансанд, 3,600.0 мянган төгрөгийн шторкны төлбөрийг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн. Мөн шторкны төлбөр, шторк цацалтын төлбөр, онцгой үеийн хоолны төлбөр, программ, оношилгооны нийт 27,667.8 мянган төгрөгийн зардлыг аж ахуйн материалын дансанд орлогоор авч, 26,590.4 мянган төгрөгөөр уг данснаас зарлага гаргаж бүртгэсэн байсныг залруулав.

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолж үзэхэд 2020 оны 4-5 саруудад худалдан авсан 7 төрлийн тавилга, эд хогшлын 358.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг тооцоолоогүй байсныг залруулав.

- Ковидтой холбогдуулан хувь хүнээс 2,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий маск, комбинзоныг, Онцгой байдлын ерөнхий газраас 9 төрлийн 1,681.8 мянган төгрөгийн хандивын бараа материалыг хүлээн авсан. Нийт 3,681.8 мянган төгрөгийн хандивын бараа материалыг бүртгэж, хандивын орлогоор аваагүй байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 929,412.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

1. Приус, Соната маркын автомашины шатахуун зарцуулалтыг жишиг нормын дагуу тооцоолоход 1,744.3 мянган төгрөг илүү тооцоолсон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 заалт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Зам тээвэр хөгжлийн сайдын “Жишиг норм батлах тухай” 390-р тогтоолыг зөрчиж, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Тайлант онд 324,455.2 мянган төгрөгийн зарлага гарснаас 108,868.1 мянган төгрөгийн гүйлгээ е-баримтаар баталгаажиж, 215,587.1 мянган төгрөгийн гүйлгээ е-баримтаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Санхүүгийн тайлангаар нийгмийн даатгалын шимтгэлийн 22,742.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 7,045.2 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Тайлант онд 1,092,769.2 мянган төгрөгийн 32 орлого, зарлагын мөнгөн гүйлгээнээс 410,478.9 мянган төгрөгийн 15 гүйлгээг шилэн дансанд мэдээлсэн. 682,293.3 мянган төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дэх заалт “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 11,306.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхийг хамарсан Ковид-19 цар тахал тархаж, хатуу хөл хорио тогтоосноос шалтгаалан цахимаар аудитыг гүйцэтгэсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэн тооллогын үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байсныг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийг шинэчлэх шаардлагатай.

Санхүү бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа программ хангамжийн хэрэгжилт, уялдаа холбоог анхаарч ажиллах шаардлагатай.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд 471.3 мянган төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжинд нийгмийн даатгалын шимтгэлийг илүү тооцож тайлагнасан, 258.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү тооцож тайлагнасан.
- 1.2. Эрсдэл: Төсвийг үр ашиггүй захиран зарцуулах, хууль тогтоомжийг мөрдөн ажиллахгүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 “Шимтгэлийн тайлан буюу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл тодорхойлох хуудсыг үндэслэн шимтгэлийн тооцоог хийх бөгөөд төлбөрийг бэлэн бус тооцооны журмаар гүйцэтгэнэ.” заалтуудыг мөрдөх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Жижиг мөнгөн сантай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Жижиг мөнгөн сангийн анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 7,417.0 мянган төгрөгийн зардал гаргасан. Нэг сая төгрөгөөс дээш дүнтэй 6,527.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 300.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй 4,050.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн.
- 2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт алдагдах, бэлэн мөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх эрсдэлтэй.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 3 дахь “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300.0 мянган төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна.” заалтыг мөрдөх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар		САГ-2021/5/СТА-ТШЗ

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү тооцоолсон.	729.3	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
2	Жижиг мөнгөн санд зөвшөөрөгдсөн хэмжээнээс их дүнгээр орлого, зарлагын гүйлгээ хийсэн.	10,577.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
3	Шатахууны зардлын нормыг хэтрүүлсэн.	1,744.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
4	Цахим төлбөрийн систем илгээгдээгүй худалдан авалтын зарлагын баримт	215,587.1	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
5	Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өртэй гарсан.	29,788.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
6	Шилэн дансанд орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй.	682,293.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Д.Одгэрэл
ДҮН		956,855.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 187 /А0160059
САГ- 2021 /5 /СТА - ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 324,455.2 /гурван зуун хорин дөрвөн сая, дөрвөн зуун таван мянга хоёр зуу/ мянган төгрөгийн зарлага гарснаас 108,868.1 /нэг зуун найман сая, найман зуун жаран найман мянга нэг зуу/ мянган төгрөгийн гүйлгээ ебаримтаар баталгаажиж, 215,587.1 мянган төгрөгийн гүйлгээ ебаримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажил гүйлгээг гарахаас нь өмнө тулган баталгаажуулж, зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Д.Одгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН

Э.НАНДИНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 186 / А0160059
САГ - 2021 / 5 / СТА - ТЦЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ШӨХТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангаар нийгмийн даатгалын шимтгэлийн 22,742.8 /хорин хоёр сая долоон зуун дөчин хоёр мянга найман зуу/ мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 7,045.2 /долоон сая дөчин таван мянга хоёр зуу/ мянган төгрөгийн өглөгтэй байна.

Энэ нь өмнөх аудитаар өгөгдсөн зөрчлийг арилгаагүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Д.Одгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АХЛАХ АУДИТОР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН

Э.НАНДИНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 185 / АО16 0059

Улаанбаатар хот

САГ-2021/5 / СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 1,092,769.2 /нэг тэрбум ерэн хоёр сая долоон зуун жаран есөн мянга хоёр зуу/ мянган төгрөгийн 32 мэдээ байршуулахаас 682,293.3 /зургаан зуун наян хоёр сая хоёр зуун ерэн гурван мянга гурван зуу/ мянган төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Д.Одгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Р.ЦОЛМОН

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Э.НАНДИНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 184/АД160059

Улаанбаатар хот

САГ-2021/5/СТА-ПЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Приус, Соната маркын автомашины шатахуун зарцуулалтыг жишиг нормын дагуу тооцоолоход 1,744.3 /нэг сая долоон зуун дөчин дөрвөн мянга гурван зуу/ мянган төгрөг илүү тооцоолсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам тээвэр хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 390-р тогтоолын 1 дүгээр хавсралтад заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахуун зарцуулалтын тооцоололд жишиг нормыг мөрдөж, дээрх зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Д.Одгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН

Э.НАНДИНЧИМЭГ

